



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№97 /541/

2023.06.15

Цаг үе, үйл явдал

## БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ ГЕРМАНЫ ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлиний цэргийн тойргийн командлагч бригадын генерал Юрген Карл Ухтманн тэргүүтэй төлөөлөгчдийг хоёр улсын Батлан хамгаалах яамд хоорондын

хамтын ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд айлчлал хийж байгаатай нь холбогдуулан хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа болон Орон нутгийн хамгаалалт, иргэн-цэргийн харилцааны удирдлага зохион байгуулалтын талаар санал солилцов.

## ХУРДАН МОРИНЫ САЛБАР ХОРОО ХУРАЛДЛАА



танилцууллаа.

Хурлын төгсгөлд Үндэсний их баяр наадмын Хурдан морины салбар хорооны дарга бригадын генерал Д.Ганхуяг гишүүдэд хандан үүрэг, чиглэл өглөө. Тэрээр "Хурдан морины салбар хорооны гишүүд та бид төр, засгаас оногдуулсан энэ ажлыг алдаа мадаггүйгээр зохион байгуулах үүргийг хүлээсэн, хамтдаа ард нь гарна гэдэгт итгэлтэй байна. Бид

батлагдсан хууль, дүрмийн хэмжээнд энэхүү ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Тиймээс хүн болгоноос хичээл зүтгэл, сэтгэл шаардагдана. Өнгөрсөн жилүүдэд бид нэг баг болж, гар нийлж ажилласан. Энэ удаад ч дааж авсан ажлаа чанартай гүйцэтгэж, наадамчин олноо баясгах орчин нөхцөл, боломжийг бүрдүүлнэ" хэмээгээд нийт бие бүрэлдэхүүнд ажлын амжилтыг хүсэв.

Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Хурдан морины салбар хороо өнөөдөр хуралдлаа.

Хурлын эхэнд Хурдан морины салбар хорооны нарийн бичгийн дарга хурандаа Г.Ялалт Үндэсний их баяр наадмыг

зохион байгуулах хорооны Бүртгэлийн дэд хороо, хэмжилт хийх ажлын хэсэг, зохион байгуулах ажлын хэсэг, даамал, дэд даамал томилох тогтоолыг танилцуулсан бол үргэлжлүүлэн тус салбар хорооны орлогч дарга бэлтгэл бригадын генерал Б.Ганбаатар гишүүдийн ажил, үүргийн хуваарийг мөн



## ӨМНӨД СУДАНЫ ИРЭЭДҮЙ БОЛСОН ХҮҮХДҮҮДЭД ...



БНӨСУ-д явагдаж буй энхийг сахиулах UNMISS ажиллагааны Юнити секторт үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт Хүчний 12 дугаар ээлжийн цэргийн баг орон нутагт энхийг сахиулахаас гадна, энхийг байгуулах, Монгол цэргийг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор идэвхтэй үйл ажиллагаа явуулсаар байна.

Дээрх зорилгын хүрээнд эхлүүлсэн төслийн нэгдүгээр үе шат Бентью суурингийн охидын сургуульд явагдсан бол энэ удаагийн үе шатыг энэ сарын 09-ний өдөр цэргийн багийн хариуцлагын бүс дахь Париян сууринд зохион байгууллаа.

Энэ өдөр Париян суурингийн төв талбайд 10 төрлийн хүүхдийн тоглоом, охидын сургуулийн

гадна талбайд 10 ширхэг хөлөгт тоглоомуудыг гарын доорх материал ашиглан хийж байрлуулсан юм.

Тус арга хэмжээнд Рувенг засаг захиргааны бүсийн дарга ноён Стефано Виэю Ди Миалэк болон орон нутгийн иргэд, хүүхэд багачууд өргөнөөр оролцлоо.

Арга хэмжээний үеэр ноён Стефано Виэю Ди Миалэк хэлсэн үгэндээ Монгол цэрэг энд байгаад манай ард иргэд амгалан тайван амарч, ажиллаж амьдардаг билээ, бидний ирээдүй болсон хүүхэд багачуудын сурч хөгжих орчин

нөхцөлийг сайжруулах, наадаж тоглоомыг хийж байршуулж байгаад ард иргэдийнхээ өмнөөс болон хувиасаа гүнээ талархаж байна. Монголын батальоны цэргүүдэд маш их баярлаж байна хэмээн онцолсон юм.

Энэхүү арга хэмжээний үеэр үндэсний урлагийн үзүүлбэрийг сонирхуулахын зэрэгцээ сургуулийн багш болон 300 гаруй хүүхдэд хичээлийн хэрэгсэл, хувцас тараан өглөө. Дээрх арга хэмжээ нь цаашид үргэлжлэн явагдах юм.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	🌧️ 7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 25

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,434	3,441
EUR 🇪🇺	3,695	3,716
CNY 🇨🇳	479	482
RUB 🇷🇺	41	41.20
JPY 🇯🇵	24	24.70
KRW 🇰🇷	2.67	2.70

### ЗУРХАЙ



2023.06.15 /ПҮРЭВ ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 27

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН  
МОГОЙ САР  
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХ  
ЛУУ ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.52-20.53

Барилдлага:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Сэрэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,298,513

Эдгэрсэн

Нийт: 662,755,345

Нас барсан

Нийт: 6,891,801

Цахим шууданд

# АРТИЛЛЕРЧИД "ЦУСНЫ ДОНОР ХАМТ ОЛОН"- ООР ӨРГӨМЖЛӨГДЛӨӨ



сийвэнгээ тогтмол хугацаанд өгөх нь аюулгүй цусны нөөц бүрдүүлэх гол үндэс төдийгүй байнга цус сэлбүүлэх шаардлагатай өвчтөнүүдийн амь насыг аварч, тэдний амьдралын баталгаа болдог билээ. Өнөөдөр шинээр 131 хүндэт донор төрснөөс хамгийн залуу нь 26 настай байгаа нь бусдын төлөө сайн дураараа цусаа хандивлахад залуучуудын оролцоо нэмэгдсэнийг харуулж байна” хэмээгээд хурандаа Э.Мөнх-Оргил захирагчтай Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хамт олныг "Цусны донор хамт олон" болсныг зарлалаа.

Бусдад амьдрал бэлэглэгч хамт олны шагналыг Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд гардуулан өгч "Коронавирусийн цар тахлын үед цус сэлбүүлэх шаардлагатай олон өвчтөнүүдэд эрхэм хүндэт донорууд өөрсдийн амь насыг үл хайрлан цусаа бэлэглэж, өвчтөнүүдийн амь насыг аварч байсанд чин сэтгэлээсээ талархал илэрхийлье" гээд анхан шатны тусламж үзүүлэх сургалтын багаж хэрэгсэл худалдан авах 2 сая төгрөгийн эрхийн бичгээр шагнасан юм.

Ахмад Т.МЯГМАРСҮРЭН

ДЭМБ-аас жил бүрийн 06 дугаар сарын 14-ний өдрийг "Цусны донорын Дэлхийн өдөр" болгон тэмдэглэдэг. Монгол Улсын хувьд энэ жил 20 дахь жилдээ тус арга хэмжээг зохион байгууллаа.

Жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулсан "Цусны донорын дэлхийн өдөр"-ийн арга хэмжээнд Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, ДЭМБ-ын Монгол дахь

суурин төлөөлөгч Др Сокуроо Эскаланте, НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Эваристе Коуасси Комлан болон үе үеийн хүндэт донорууд, сайн дураараа цусаа хандивлагч хамт олон, иргэд оролцлоо.

Дэлхийн өдрийн арга хэмжээг ЦССҮТ-ийн ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр нээж хэлсэн үгэндээ "Сайн дураараа, авлагагүйгээр цус,

# ЦЭРГИЙН ХҮҮ ШҮЛЭГЛЭН ГҮЙЖ ЯВНА



Төв аймгийн болон Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн 100 жилийн ойг угтаж тус нэгтгэлийн ахлагч тэргүүн ахлагч Б.Алтангэрэл өөрийн санаачилгаар алсын зайн гүйлт хийхээр өнгөрөгч сарын 25-ны өдөр Төв-Дорноговь аймгийн чиглэлд замдаа гарсан билээ.

Тэрээр 23 дахь өдөртөө 902 километр замыг туулж байгаа бөгөөд өнөөдөр буюу 6 дугаар сарын 16-ны өдрийн морин цагт Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод хүрэлцэн очсон юм.

Тэргүүн ахлагч Б.Алтангэрэлийг Сүхбаатар аймгийн

уширлага, Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн хамт олон ёслол төгөлдөр хүлээн авч, амжилт хүсэв.

Цэргийн хүү Тэнгэр, гангын халуунд үүлэн сүүдрээ илгээгээд байх шиг Талын салхи түрэн, "Гүйгээд" гэж команд өгөх шиг

Таарсан олон инээмсэглэн, даллахад хариу ёслол хүндэтгэсэн Тэргүүндээ алтан соёмботой цэргийн хүн би

Газрын холдоо дуу аялан ханьссан Газар шороо чулуутайгаа хамт гүйж явна ... хэмээн шүлэглэн гүйсээр л...

Хошууч О.ГЭРЭЛЗАЯА

# "ДАЙЧИН ЗАМНАЛ-ТҮҮХ СУРГАМЖ" ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл түүхт 100 жилийн ойгоо угтаж бэлэн байдлыг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ая тухтай орчинд ажиллах нөхцөлийг сайжруулах, аймаг орон нутагтаа цэргийн албыг сурталчлах төлөвлөн хэрэгжүүлж байна.

Түүхт ойг угтсан нэг томоохон ажил болох "Дайчин замнал-түүх сургамж" эрдэм шинжилгээний бага хурал өнөөдөр буюу энэ сарын 16-ны өдөр амжилттай явагдлаа.

Эрдэм шинжилгээний бага хуралд Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дайчилгааны офицер хошууч Б.Бадарч, нэгтгэлийн ахмадын зөвлөлийн дарга бэлтгэл байгаа хурандаа Н.Нямхүү, гишүүн бэлтгэл байгаа дэд хурандаа С.Одсүрэн, нэгтгэлийн удирдлага, хамт олон, мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийн

түрүүч, байлдагч нар оролцлоо.

Хурлыг нэгтгэлийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр нээж хэлсэн үгэндээ "Энэ жил нэгтгэлийн түүхт 100 жилийн ой тохиож байна. Бид бүхэн 100 жилийнхээ ойг угтан олон ажил, арга хэмжээ зохион байгуулж байгаагийн нэг томоохон арга хэмжээ нь энэхүү "Дайчин замнал-түүх сургамж" эрдэм шинжилгээний бага хурал юмаа. Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулснаар Монгол Улсынхаа түүхэн үйл явдал, бахдам үйлс, алдар гавьяа, нэгтгэлийн дайчин түүхэн замналыг судлан мэдэх, бие бүрэлдэхүүнд сурталчлан таниулах, илтгэгч нарын судалгааны арга зүй, илтгэх ур чадварыг хөгжүүлсэн ихээхэн ач холбогдолтой болохыг та бүхэндээ хэлэхэд таатай байна. Бид бүхэн нэгтгэлийнхээ хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрх, итгэл зүтгэлээ зориулан хамтран ажиллаж, ажил

бүхний ард амжилттай гарна гэдэгт итгэлтэй байна" хэмээн дурдсан юм. Ингээд Монгол Улсын төрийн дууллаа эгшиглүүлэн илтгэлүүд эхэлсэн байна.

Эрдэм шинжилгээний бага хуралд мотобуудлагын батальоны II ротын соёл хүмүүжлийн зааварлагч дэслэгч А.Эрдэнэчимэг "1921 оны үндэсний ардчилсан хувьсгал, хувьсгалын ялалт, ач холбогдол", ажиллагааны офицер ахмад Д.Ариунболд "Нэгтгэлийн түүхэн замнал, ололт амжилт", ахмадын зөвлөлийн гишүүн бэлтгэлд байгаа дэд хурандаа С.Одсүрэн "1930-1932 оны дотоодын үймээн самуун ба хилийн мөргөлдөөн, түүнд нэгтгэлийн оролцоо", эрүүл мэндийн төвийн дарга ахлах дэслэгч С.Сувданчимэг "1932-1936 оны алс дорнод дахь тулаан түүнд нэгтгэлийн оролцоо", зэвсгийн албаны дарга хошууч М.Алтангэрэл "1939 оны халх голын дайн түүнд нэгтгэлийн оролцоо", нэгтгэлийн ажиллагааны ахлагч сургагч ахлагч Д.Чулуунсүх "Энхийг дэмжих ажиллагаа түүнд Монгол Улсын Зэвсэгт хүчин, нэгтгэлийн оролцоо", захирагчийн сургалт бэлтгэл хариуцсан орлогч дэд хурандаа И.Эрдэнэсүрэн "Орчин үеийн дайн, түүний шинж чанар, хэтийн төлөв" зэрэг сэдвүүдээр тус бүр 15 минутын хугацаатай илтгэл тавилаа. Монгол Улсын түүхэн үйл явдалд нэгтгэлийн үүрэг, оруулсан хувь нэмрийн талаар тавигдсан илтгэлүүд үзэгчдийн сонирхлыг ихээхэн татаж байсан юм.

Эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл тавьсан офицер, ахлагч нарт нэгтгэлийн захирагчийн талархал, дурсгалын зүйлийг гардуулан, ая дууны мэндчилгээ өргөн дэвшүүлснээр хурал өндөрлөлөө.

Хошууч О.ГЭРЭЛЗАЯА



# УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн Эрүүл мэндийн төвөөс санаачлан Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтарч энэ сарын 13-ны өдрөөс 16-ны өдрүүдэд ангийн байнгын бүрэлдэхүүн, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан

сэргийлэх үзлэгт хамруулав. Энэ үеэр аймгийн нэгдсэн эмнэлгийн мэдрэл, сэтгэц, мэс засал, эрэгтэйчүүд, дотор, шүд, эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч нар бүрэн бүрэлдэхүүнээр ажилласан юм.

Дэслэгч М.АНХЖАРГАЛ

